



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

---

**ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ТАЙЛАН**  
**/2020 оны III улирал/**

---

**ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ  
ТАЙЛАН**

/2020 оны III улирал/


Хөдөлгөөнт банкны үйлчилгээ үзүүлэгч нийт 12 банкнаас 2020 оны III улирлын байдлаар гаргасан тайланг нэгтгэн, хэрэглэгчийн тоо ба гүйлгээний дүнг интернэт болон мобайл хандалтын төрлөөр ангилан өмнөх он ба улиралтай харьцуулан авч үзлээ.

**1. ИНТЕРНЭТ ХАНДАЛТ<sup>1</sup>**

• **Хэрэглэгчийн тоо**

Хөдөлгөөнт банкны 2020 оны III улирлын тайлангийн дүнгээр улсын хэмжээнд нийт 2.5 сая интернэт хандалтын эрхтэй хэрэглэгч байгаа нь өмнөх оны III

улиралтай харьцуулахад 670 мянган хэрэглэгчээр буюу 36.6 хувиар өссөн байна. Шинээр 102 мянган хэрэглэгч хот суурин газарт бүртгүүлсэн байна (хавсралтын Хүснэгт 1а,б). Зураг 1-д интернэт хандалтын эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймгаар тус тусад нь авч үзвэл 2020 оны III улирлын байдлаар 77.3 хувийг хот суурин газар, үлдсэн 22.7 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад нийт бүртгэлтэй хэрэглэгчдэд эзлэх орон нутгийн хэрэглэгчдийн хувь 22.7 байснаас 24.5 хувь болж өсжээ.



<sup>1</sup> Интернэт протокол ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авах

Тус үйлчилгээгээр сард 3 ба түүнээс дээш удаа гүйлгээ хийж, интернэт банкыг идэвхтэй ашиглаж байгаа нийт 1.2 сая хэрэглэгч байгаа нь өмнөх онтой харьцуулахад 70 мянгаар буюу 6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд шинээр интернэт хандалтын эрх авахаар 139.7 мянган хэрэглэгч бүртгүүлсэн нь өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 2.8 мянган хэрэглэгчээр буюу 2.1 хувиар өссөн байна (Хүснэгт 1б).

- **Гүйлгээний тоо, дүн**

Тайлант хугацаанд интернэт хандалтаар нийт 29.3 их наяд төгрөгийн 73.4 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны III улирлаас дүнгийн хувьд 1.3 их наяд төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан ч, гүйлгээний тооны хувьд 13.3 сая ширхэг гүйлгээгээр буюу 22.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна (хавсралтын Хүснэгт 2а,б). Тус гүйлгээг үйлчилгээний төрлөөр ангилбал:

- Цахим хуудас – 12.2 их наяд төгрөгийн 7.1 сая ширхэг;
- Гар утасны аппликэйшн – 17 их наяд төгрөгийн 66.2 сая ширхэг гүйлгээ тус тус хийгдсэн байна (Хүснэгт 2а).

## 2. МОБАЙЛ ХАНДАЛТ<sup>2</sup>

- **Хэрэглэгчийн тоо**

Хөдөлгөөнт банкны 2020 оны III улирлын тайлангийн дүнгээр улсын хэмжээнд 1.3 сая мобайл хандалтын эрхтэй хэрэглэгч бүртгэгдсэн нь өмнөх оны III улиралтай харьцуулахад 123.1 мянган хэрэглэгчээр буюу 8.4 хувиар буурсан. Тус үйлчилгээг 2020 оны III улирлын байдлаар 549.3 мянган хэрэглэгч идэвхтэй ашиглаж байна. Энэ нь өмнөх оны үзүүлэлтээс 196.3 мянга буюу 26.3 хувиар буурсан байна. Мобайл банкны хэрэглэгчдийн тоо эрс буурсан байгаа нь тайлангийн загварын шинчлэлтэй холбоотойгоор давхар бүртгэдэг байсныг нарийвчлан бүртгэдэг болсонтой холбоотой юм. Мобайл хандалтын эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймгаар тус бүрээр авч үзвэл III улирлын байдлаар 56.8 хувийг хот суурин газар, үлдсэн 43.2 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байгааг Зураг 1-д үзүүлэв.

Тайлант хугацаанд шинээр мобайл хандалтын эрх авахаар 67 мянган хэрэглэгч бүртгүүлснээс 26.8 мянга буюу 40 хувь нь орон нутагт бүртгэлтэй байна (хавсралтын Хүснэгт 1а).

---

<sup>2</sup> USSD, SMS зэрэг үүрэн холбооны технологи ашиглан хөдөлгөөнт банкны үйлчилгээ авах

- **Гүйлгээний тоо, дүн**

Тайлант хугацаанд мобайл хандалтаар нийт 2.5 их наяд төгрөгийн 32.9 сая ширхэг гүйлгээ хийгдсэнийг үйлчилгээний төрлөөр ангилан хавсралтын Хүснэгт 2а-д үзүүлэв. Гүйлгээний тоо, дүнг өмнөх оны III улиралтай харьцуулж үзэхэд гүйлгээний тооны хувьд 41.6 хувиар буюу 9.7 сая ширхэг гүйлгээгээр өссөн бол, дүнгийн хувьд 22.8 хувиар буюу 732 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна (хавсралтын Хүснэгт 2б).

### **3. ТЕЛЕФОН БАНК<sup>3</sup>**

- **Хэрэглэгчийн тоо**

Хөдөлгөөнт банкны 2020 оны III улирлын тайлангийн дүнгээр улсын хэмжээнд нийт 393 мянган телефон банкны эрхтэй хэрэглэгч байна. Үүнээс 21.1 мянган хэрэглэгч тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн байна. Телефон банкны эрх бүхий хэрэглэгчдийг хот, аймгаар тус тусад нь авч үзвэл 2020 оны III улирлын байдлаар 51.6 хувийг хот суурин газар, үлдсэн 48.4 хувийг орон нутгийн хэрэглэгчид эзэлж байна (хавсралтын Хүснэгт 1а).

- **Гүйлгээний тоо, дүн**

Тайлант хугацаанд телефон банкаар нийт 47 тэрбум төгрөгийн 237 мянган ширхэг гүйлгээ хийгджээ (хавсралтын Хүснэгт 2а).

#### **Гэрээт хамтрагч**

Улсын хэмжээнд нийт 598 гэрээт хамтрагч үйл ажиллагаа явуулж байна. Хотуудын хувьд үүнээс 526 буюу 88 хувь нь Улаанбаатарт, 10 нь Дарханд, 4 нь Эрдэнэтэд, харин бусад орон нутгаар 58 гэрээт хамтрагч хөдөлгөөнт банкны үйлчилгээг ашиглан өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулж байна (хавсралтын Хүснэгт 3).

---

<sup>3</sup> Тусгай дугаарт холбогдон хөдөлгөөнт банкны үйлчилгээ авах

**Залилангийн болон хулгайн гүйлгээ**

Тайлант хугацаанд хөдөлгөөнт банкны төрлүүдээс Интернэт хандалтаар нийт 45 удаагийн үйлдлээр 48.5 сая төгрөгийн, Мобайл хандалтаар 1 удаагийн 300 мянган төгрөгийн залилангийн гүйлгээ хийгдсэн. Харин хулгайн гүйлгээний хувьд зөвхөн Интернэт хандалтаар нийт 68 удаагийн үйлдлээр 101.3 сая төгрөгийн хулгайн гүйлгээ хийгджээ (хавсралтын Хүснэгт 4).



II. ХӨДӨЛГӨӨНТ БАНКНЫ ТАЙЛАН

Хүснэгт 1а. Хөдөлгөөнт банкны хэрэглэгчийн тайлан - Хот, аймаг

01/07/2020 - 30/09/2020

№	Хот, аймаг	Интернэт хандалт			Мобайл хандалт			Телефон банк			Нийт бүртгэлтэй цахим хэрэглэгч
		Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	
1	Улаанбаатар	93,435	1,735,149	744,785	35,891	666,501	241,018	10,645	186,680	2,374	2,588,330
2	Дархан-Уул	4,205	82,331	36,089	2,089	49,617	23,125	477	7,120	355	139,068
3	Орхон	4,562	70,059	31,548	2,243	46,355	19,003	594	8,958	171	125,372
	Нийт (дээрх хотууд)	102,202	1,887,539	812,422	40,223	762,473	283,146	11,716	202,758	2,900	2,852,770
	Нийт эзлэх %	73.18%	75.51%	74.06%	60.01%	56.84%	51.55%	55.62%	51.59%	14.83%	67.37%
4	Бусад аймаг	37,464	612,345	284,539	26,809	579,000	266,148	9,348	190,231	16,659	1,381,576
	Нийт эзлэх %	26.82%	24.49%	25.94%	39.99%	43.16%	48.45%	44.38%	48.41%	85.17%	32.63%
	Нийт (Улс)	139,666	2,499,884	1,096,961	67,032	1,341,473	549,294	21,064	392,989	19,559	4,234,346

Хүснэгт 1б. Нийт хэрэглэгчдийн тоо

2019-2020

	Интернэт хандалт			Мобайл хандалт			Телефон банк			Нийт бүртгэлтэй цахим хэрэглэгч
	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Тайлант хугацаанд шинээр бүртгүүлсэн	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	
2019-III улирал	136,866	1,829,883	1,167,001	84,709	1,464,615	745,572	0	0	0	3,294,498
2020-III улирал	139,666	2,499,884	1,096,961	67,032	1,341,473	549,294	21,064	392,989	19,559	4,234,346
Өөрчлөлт	2,800	670,001	-70,040	-17,677	-123,142	-196,278	21,064	392,989	19,559	939,848
Өөрчлөлт (хувиар)	2.05%	36.61%	-6.00%	-20.87%	-8.41%	-26.33%	-	-	-	28.53%

Хүснэгт 2а. Хөдөлгөөнт банкны гүйлгээний тайлан - Гүйлгээний төрлөөр

01/07/2020 - 30/09/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төрөл/суваг	Интернэт хандалт				Мобайл хандалт		Телефон банк		Нийт		
		Цахим хуудас		Гар утасны аппликейшн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн							
1	Банк дотор	3,360.52	6,900.10	51,685.01	13,138.37	31,746.61	2,265.66	237.35	47.43	87,029.49	22,351.56	
2	Банк хооронд	2,170.68	3,292.09	13,033.13	3,543.43	869.51	140.74	0.00	0.00	16,073.32	6,976.26	
3	Олон улсын гүйлгээ	13.77	537.70	2.18	25.66	0.00	0.00	0.00	0.00	15.95	563.36	
4	Картын гүйлгээ	37.41	33.82	175.12	60.22	0.99	0.21	0.00	0.00	213.52	94.24	
5	Зээл төлөлт	106.62	72.61	352.56	297.62	128.90	73.20	0.00	0.00	588.08	443.43	
6	Төлбөр	Торгуулийн төлбөр	13.12	0.30	1.72	0.05	0.00	0.00	0.00	0.00	14.84	0.35
		Татвар төлөлт	48.78	84.91	0.53	0.04	0.00	0.00	0.00	0.00	49.31	84.96
		Гаалийн төлбөр	145.09	339.75	3.65	3.58	0.00	0.00	0.00	0.00	148.75	343.33
		Даатгал	1.01	0.51	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1.01	0.51
		Хэрэглээний төлбөр	602.77	46.67	557.35	12.53	120.04	0.78	0.00	0.00	1,280.16	59.98
	Бусад	515.82	4.69	13.17	0.12	0.00	0.00	0.00	0.00	529.00	4.81	
7	Хөдөлгөөнт банкны процессор	103.50	864.53	422.74	21.76	0.00	0.00	0.00	0.00	526.23	886.28	
8	Нийт	7,119.08	12,177.69	66,247.17	17,103.37	32,866.06	2,480.59	237.35	47.43	106,469.65	31,809.07	

Хүснэгт 2б. Хөдөлгөөнт банкны гүйлгээний тайлан - Гүйлгээний төрлөөр

01/07/2020 - 30/09/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

	Интернэт хандалт		Мобайл хандалт		Телефон банк	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2019-III улирал	60,055.87	30,531.96	23,215.77	3,213.38	0	0
2020-III улирал	73,366.25	29,281.05	32,866.06	2,480.59	237.35	47.43
Өөрчлөлт	13,310.38	-1,250.91	9,650.29	-732.79	237.35	47.43
Өөрчлөлт (хувиар)	22.16%	-4.10%	41.57%	-22.80%	-	-

Хүснэгт 3. Гэрээт хамтрагчийн тайлан – Хот, аймаг

01/07/2020 - 30/09/2020

Гэрээт хамтрагчийн тоо				Нийт
Улаанбаатар	Дархан-Уул	Орхон	Бусад аймаг	
526	10	4	58	598

Хүснэгт 4. Хулгайн болон хулгайн гүйлгээний тайлан

01/07/2020 - 30/09/2020

	Интернэт хандалт				Мобайл хандалт		Телефон банк		Нийт	
	Цахим хуудас		Гар утасны аппликейшн							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залилангийн гүйлгээ	32	35,827,900.00	13	12,689,000.00	1	300,000.00	0	0.00	46	48,816,900.00
Хулгайн гүйлгээ	35	33,982,500.00	33	67,286,700.00	0	0.00	0	0.00	68	101,269,200.00